МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2023.05.19 № А-1/2032

танай ________________-ны № ________________-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

Тодруулгад хариу хүргүүлэх тухай

Тус газраас зарласан ТХААГ/202304100 дугаартай XIII.1.3.10.6 Ерөнхий боловсролын сургуульд “Байгалийн ухаан”-ы лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариултыг хүргүүлж байна.

1. Тус төсөл, арга хэмжээг багцлахдаа захиалагч Боловсрол, шинжлэх ухааны яамнаас ирүүлсэн техникийн тодорхойлолтын дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт заасныг үндэслэн өрсөлдөөнийг дэмжих зорилгоор барааны зориулалтыг харгалзан ижил төстэй байдлаар нь багцалсан.
2. Багц-7-4: XIII.1.3.10.6 “Байгалийн ухаан”-ы лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах-Дизайн технологийн хичээлийн лаборатори багцад дизайн технологийн эрэгтэй, эмэгтэй тоног төхөөрөмж хамаарах бөгөөд хүйсээр ангилж хуваан багцлах боломжгүй байна.

Мөн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийн тухайн төсөл, арга хэмжээний ТЭЗҮ хэсэг дэх техникийн тодорхойлолтын нэрсийг тендерийн баримт бичгийн тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан багцуудын нэрээр өөрчилсөн болно.

ДАРГА Ц.БАТЗУЛ

9020020105 СБТ-11261 6529909

132327178

ТХААГ-2023-А4